

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

ДУГНЭЛТ:

Төсөвт байгууллагууд батлагдсан төсвөөс 32779.5 мянган төгрөгийн зориулалт бус зарцуулалт гаргасан, Засаг даргын захирамжийн биелэлт хангалтгүй байна.



Аудитын нэр:

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн

**Баруун-Урт сум
2017 он**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:**Аймгийн Аудитын газар**

Сүхбаатар аймаг
дахь Төрийн аудитын
газрын дарга,
тэргүүлэх аудитор М.Нарантуяа

Аудитын менежер Г.Даваа

Ахлах Аудитор: С.Ариунбаяр

Аудитор: Ө.Золзаяа

2017 оны 09 дугаар сарын 25-ны өдөр

Уг тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Веб сайт-аас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал багийн утас 70512127, Газрын дарга, тэргүүлэх аудитор 70518396 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Аймгийн аудитын газар Баруун-Урт сум 7-р баг төрийн захиргааны байр өрөөний дугаар 226 тоот

Сүхбаатар аймаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Товчилсон үгийн тайлбар

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Аймгийн аудитын газрын тайлбар

Төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталснаас орлого 38.6 сая төгрөгөөр тасарсан байна

Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, хөрөнгө зарцуулах тухай тушаал шийдвэрийг алдаатай, буруу гаргадаг зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон хандив тусламжаар бэлтгэсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулснаас зарим хөрөнгө устаж үгүй болсон, ашиглалтын шаардлага хангахгүй байдалтай байна

Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн биелэлт 87.1%-тай хэрэгжүүлжээ

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, мал хамгаалах сангаас 20.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна

ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн 2016 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна

Сумын ЭМТ тодорхой зорилго, зорилт дэвшүүлээгүй, стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байна

Сумын Засаг даргын захирамжийн биелэлтийг бодитой тооцоогүй, үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна

Аудитын явцад өмнөх аудитуудаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангууллаа

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын 30%-ийг мэргэжилтнүүдийн ажлын цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбоотой өргөдөл гомдол эзэлж байна

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлжээ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/16

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай


Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, 11, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар тогтоосон акт, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 22-ны дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Засаг дарга /Ө.Батсайхан/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудитор 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт

Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгнө. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн
- Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчдын үр дүнгийн гэрээний биелэлт
- Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт түүнд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй эсэх

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төсвийн байгууллагуудын 2016 оны орлого, санхүүгийн баримт материал, бодлогын бичиг баримт, үйл ажиллагааны холбогдох баримт материалуудыг хамруулан шалгалаа.

4. Үндсэн мэдээлэл

Эрдэнэцагаан сумын орон нутгийн төсвийн орлогыг 2016 онд 186.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 147.6 сая төгрөг төвлөрч 38.5 сая төгрөгөөр тасарсан байна. Төсвийн орлого биелээгүй нь үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр төсөвлөсөнтэй холбоотой байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2614.8 сая, хөрөнгийн зардалд 452.1 сая бусад 100.0 сая нийт 3170.5 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2787.7 сая төгрөг зарцуулжээ.

Төсвийн гүйцэтгэлээр 382.8 сая төгрөг хэмнэгдсэн харагдаж байгаа боловч сум хөгжүүлэх сангаас 4.0 сая төгрөгийн зээл олгогдоогүй, ОНХС-аас 323.7 сая, БХС-аас 8.2 сая, МХС-аас 1.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлджээ. Төсөвт байгууллагуудаас хэмнэгдсэн 2.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн төсвийн орлого тасарсантай холбоотойгоор ИТХ болон ЗДТГ-ын санхүүжилт 42.9 сая төгрөгөөр дутуу олгогдсон нь тус тус нөлөө үзүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан төсвийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 40.0 сая төгрөг төвлөрснийг урсгал зардалд зарцуулжээ. 2016 оны СТА-аар сумын төвлөрүүлэн захирагчийн жилийн эцсийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт хүргүүлсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 392.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг залруулах аудитын зөвлөмж хүргүүлсэн байна. Мөн өмнөх онуудад хийгдсэн СТА-аар өгөгдсөн ЭМТөвийн 1.0 сая төгрөгийн акт, ОНХС-гийн 5.0 сая төгрөг, УТХО-ын аудитаар өгсөн 6.9 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжээгүй байна.

Мөн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 229.0 сая төгрөг байснаас тайлант онд 117.3 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 346.4 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд нийт авлагын 91.6 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл эзлэж байгаа нь зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь төлүүлэх ажил хангалтгүй байгаатай холбоотой байна.

5. Аудитын эрсдлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн /Эрсдэлийн үнэлгээг хавсралт №2-д үзүүлэв./

6. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу аудитын арга зүйг мөрдөж, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын удирдлага болон ажилтан албан хаагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. (Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №1-т үзүүлэв.)

7. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Соёлын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Боловсролын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Соёлын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, НББОУС болон холбогдох бусад хууль, тогтоомжуудыг шалгуур үзүүлэлт болгож ашиглалаа.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг ахлах аудитор С.Ариунбаяр, аудитор Ө.Золзаяа нар хийж гүйцэтгэв.

9. Аудитын хугацаа

Аудитын төлөвлөгөөг 2017 оны 8 дугаар сарын 25-аас 09 сарын 04, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 09 сарын 6-аас 9 сарын 16, тайлагналын үе шатыг 9 сарын 18-аас 9 сарын 25-ыг хүртэл хийж гүйцэтгэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БХС	Байгаль хамгаалах сан
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МХС	Мал хамгаалах сан
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТА	Санхүү тайлангийн аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ШТМ	Шатах тослох материал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЯХИС	Японы хүүхдийг ивээх сан
ББНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар

Төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн орлогыг тооцоо судалгааны үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталснаас орлого 38.6 сая төгрөгөөр тасарсан байна.

1.1.1 Эрдэнэцагаан сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 06 тоот тогтоолоор сумын төсвийн орлогыг 151.4 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 34.8 сая төгрөгөөр нэмж гүйцэтгэлээр 147.6 сая төгрөг төвлөрч, 38.6 сая төгрөгөөр тасарчээ. Үүнд сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэх болсон шалтгаан нөхцлийг тодорхой эдийн засгийн судалгаатай боловсруулаагүй, улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзээгүй, суурь судалгаа тооцоололгүй таамаглал төдий мэдээлэлд үндэслэсэн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлжээ.

№	Татварын төрөл	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл		Нийт орлогод эзлэх хувь	Тасарсан (Давсан) /сая.төг/
			Сая.төг	Хувь		
1	Үйл ажиллагааны орлого	68.8	38.3	55.6	26	-30.5
2	Бууны албан татвар	2.9	1.3	44.8	1	-1.6
3	Улсын тэмдэгтийн хураамж	22.5	5.7	25.3	3.8	-16.8
4	Хог хаягдлын хураамж	1.5	0	0	0	-1.5
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	21.9	2.9	13.2	2	-19.0
6	Ус ашигласны төлбөр	2.9	0	0	0	-2.9
7	Хүү торгуулийн орлого	13.0	23.6	181.5	15.9	10.6
8	Бусад нэр заагдаагүй орлого	50.8	75.8	149.2	51.3	25.0
	Нийт	186.2	147.6	79.2	100	-38.6

1.1.2 Төсвийн орлого тасарсан (давсан) шалтгааныг авч үзвэл:

- **Үйл ажиллагааны орлого:** Тайлант онд төлөвлөсөн орлогоос 30.5 сая төгрөгөөр тасарсан нь Хятад улс руу экспортлож байсан өвсийг 2016 оны намар хилээр гаргахыг хориглосонтой холбоотой байна.
- **Бууны албан татвар:** Өмнөх оны мэдээллээр сумын хэмжээнд 300 гаруй галт зэвсэг бүртгэлтэй байснаас тухайн онд 212 ширхэгээр буурч 88 ширхэг буу тоологдсон байна. Галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг цаг хугацаанд нь хийдэггүй, хяналт хангалтгүй хэрэгжсэнээс уг орлого тасарчээ.
- **Улсын тэмдэгтийн хураамж:** УТХураамжийн орлогын төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа “Бичигт боомт”-оор дамжин өнгөрөх гадаадын харьяатаас авах улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсвийн орлогод тусгаж батлуулсан нь орлого тасрах гол шалтгаан болжээ. Учир нь “Бичигтийн боомт”-оор дамжин өнгөрөх гадаадын харьяатаас авах улсын тэмдэгтийн хураамж аймгийн төсвийн орлогод төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

- Хог хаягдлын хураамж: Хог хаягдлын хураамж авах эрх зүйн акт батлагдсан боловч Сумын ИТХ-аас үнэ тарифийг тогтоож өгөөгүйгээс 1.5 сая төгрөгөөр тасарчээ.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: Тус орлогыг төлөвлөхдөө бүтээн байгуулалт, зам засварын ямар ажил үйлчилгээ хийх талаар судалгаа шинжилгээ хийлгүй өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөсөн байна. Энэ нь 2015 онд тус суманд барилга угсралт, зам талбайн засвар, бүтээн байгуулалтын ажил их хийгдснээс тус нэр төрлийн татварын орлого давж биелэсэн байна. Тайлант онд ОНХНС-аас санхүүжилт оройтож хийгдснээс /оны эцэст 320.0 сая төгрөг ОНХС-ийн дансанд төвлөрсөн/ бүтээн байгуулалт, зам засвар, барилга угсралтын болон засварын ажил зогсонги байдалтай байснаас 19.0 сая төгрөгөөр орлого тасарахад нөлөөлсөн байна.
- Ус ашигласны төлбөр: Эрдэнэцагаан суманд 2016 онд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбогдох аж ахуйн нэгж байгууллагууд ажиллаагүйн улмаас 2.9 сая төгрөгийн орлого тасарсан байна.

Харин давж биелэсэн орлогын хувьд:

- Хүү торгуулийн орлого: Хүү торгуулийн орлого 10.5 сая төгрөгөөр давсан нь захиргааны хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой байна.
- Бусад нэр заагдаагүй орлого: Тус орлого нь хадлангийн газрын төлбөрөөс бүрдсэн орлого бөгөөд 2016 онд 24.9 сая төгрөгөөр давсан. Тайлант онд төлөвлөсөн га талбайгаас илүү зөвшөөрөл олгосон нь уг орлого давахад нөлөөлжээ.

Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, хөрөнгө зарцуулах тухай тушаал шийдвэрийг алдаатай, буруу гаргадаг зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн

1.2.1 Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг батлагдсан төсөв, төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, төсвийн зарлагын гүйлгээ, журнал, дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Сумын ИТХ: ИТХ-ын цалингийн сангаас БИНХ-ын дарга нарын нэмэгдэл урамшуулалд 638.7 мянга, мэдээлэл технологийн зардлаас зочид төлөөлөгчдийг хүлээн авахад 677.5 мянган төгрөгийг зориулалт бус, томиллогод анхан шатны баримтын бүрдэл дутуу 116.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил дутагдалд албан шаардлага хүргүүлжээ. Сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан Д.Нандинцэцэгийг үндэслэлгүй ажлаас нь халсан болохыг шүүх тогтоож ажилгүй байсан хугацааны цалинг олгох шийдвэр гарсан байна. Цалингийн сангаас уг нөхөн олговорт 15129.1 мянган төгрөг зарцуулсан бөгөөд ажлаас үндэслэлгүй халсан, буруу тушаал шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар нөхөн төлбөрийг төлүүлж, төсвийг хохиролгүй болгох чиглэлээр хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Мөн хурлын ажилтны орон тоонд төрийн албаны сонгон шалгаруулалтанд тэнцээгүй хүнийг авч ажиллуулж, төрийн захиргааны албан хаагчийн цалингийн зэрэглэл, шатлалаар цалинжуулж байна. Иймд сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг ажлын байрны

тодорхойлолтын хамт аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, уг ажлын байранд тэнцсэн хүнийг томилох шаардлагатай байна.

- **Бүрэн дүнд сургууль:** Цалингийн сангаас малчин цалинжуулах буюу туслах аж ахуйн зардалд 4985.9 мянга, гэрэл цахилгааны зардлаас урсгал засварын зардалд 2000.0 мянга нийт 6985.9 мянган төгрөгийн төсвийг зориулалт бус, тендер сонгон шалгаруулалтгүйгээр сантехникийн их засварт 29000.0 мянган төгрөг зарцуулж, шууд гэрээ байгуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй 733.9 мянган төгрөгийн материалыг бараа материалын тайланд орлого, зарлагаар бүртгэсэн зөрчил дутагдалд албан шаардлага хүргүүллээ. Сургуулийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Г.Алтан-очир нь багш нарын ээлжийн амралтын цалинг бодохдоо өмнөх оны амралтын цалинг нэмж тооцоолсоноос 3149.9 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- **Сумын ЭМТ:** Цалингийн сангаас малчин цалинжуулах буюу туслах аж ахуйн зардалд 2304.0 мянга, батлагдсан төсвөөс 1319.5 мянган төгрөгийг тус тус зориулалт бус, ЭМТ-ийн эрхлэгчид сумын Засаг даргын шийдвэргүйгээр 389.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил дутагдал илэрлээ. Уг зөрчил дутагдлыг давтахгүй байх, зөрчлийг залруулж, арилгах талаар албан шаардлага хүргүүллээ.
- **Сумын Хүүхдийн I цэцэрлэг:** Эрхлэгч Засаг даргын тушаал шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулалд 711.2 мянга, хичээл үйлвэрлэлийн зардлаас 435.0 мянга, нийт 1146.2 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсанд албан шаардлага хүргүүллээ.
- **Сумын Хүүхдийн II цэцэрлэг:** Багш ажилчдад үр дүн, ур чадварын нэмэгдлийг олгохдоо хүчингүй болсон СӨБ-ын тухай хуулийн 17.1.1 болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг үндэслэн 1393.2 мянган төгрөг зарцуулсан зөрчилд зөвлөмж өглөө.
- **Соёлын төв:** Үйл ажиллагааны орлого 2521.4 мянган төгрөгийг касс туслах авахдаа анхан шатны баримт үйлдээгүй, орлогоос 806.4 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлэлгүйгээр захиран зарцуулсан, түлш халаалтын зардлаас 260.4 мянган төгрөгийг томилолтын зардалд зориулалт бус зарцуулсан, хатуу түлшийг худалдан авсан тухай бүр орлого аваагүйгээс тайланд нийт дүнгээр буюу 7680.0 мянган төгрөгөөр материалын тайланд орлого авч зарлагадсан алдаа зөрчилд зөвлөмж өглөө.
- **ЗДТГ:** Бэлэн мөнгөний ажил гүйлгээ гаргахдаа Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журамд заасан хэмжээнээс илүү буюу 3595.0 мянган төгрөгийн гүйлгээ гаргасанд зөвлөмж хүргүүллээ.

1.2.2 Төсөвт байгууллагууд бэлэн мөнгөөр нийт 21715.7 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж зарцуулалт гаргасан боловч кассаар тайлагналгүй шууд зардалд илэрхийлсэн байна. Мөн тээврийн хөлсөнд 27775.5 мянган төгрөг бодож, ажил үйлчилгээний хөлсийг бензин шатахуунаар тооцож олгосон байна. Энэ нь ажил үйлчилгээний хөлсөөс ХХОАТ-ыг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй зөрчил юм. Иймд дээрх зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүллээ. Мөн төсөв захирагч нар төсөв хөрөнгө зарцуулах, албан тушаалтан томилох, чөлөөлөх захирамж, тушаал шийдвэр гаргахдаа тушаалын үндэслэлийг буруу гаргадаг нийтлэг зөрчил дутагдлууд илэрч байна. Тухайлбал: Тус сумын хүүхдийн цэцэрлэгүүдийн эрхлэгч, ЕБС-ийн захирал нар багш, ажилчдын улирлын үр дүнгийн урамшуулал олгох тушаалын үндэслэлийг өөр өөр хуулийн заалтын дагуу олгож байна. Учир нь улирлын үр дүнгийн урамшуулалыг ЗГ-ын 2013 оны 393 тоот журмыг үндэслэн олгох нь зүйтэй юм. Мөн төсөв захирагч нар ажилтан албан хаагч томилж чөлөөлөхдөө хуулийн

заалтыг буруу хэрэглэснээр тухайн ажилтантай холбогдуулан гарах төсөв хөрөнгөтэй холбоотой хөдөлмөрийн маргаан үүсэх эрсдэл өндөр байна. Жишээ нь: Засаг даргын 2016 оны А/179 захирамжаар сумын орлогч даргаар Г.Алтан-Очирыг томилсон боловч 2016 оны А/187 тоот “Ажлаас чөлөөлж, ажилд томилох” тухай захирамжинд Г.Алтан-Очирыг ажлаас чөлөөлөх үндэслэл тусгагдаагүй, ажилд томилогдож байгаа Д.Нандинцэцэгийн томилогдох үндэслэл зэргийг дутуу тусгаснаас маргаан гарах нөхцөл үүссэн байна.

1.2.3 Дээрх алдаа зөрчлүүд нь “Төсвийн тухай” хуулийн 7.7¹, 16.5.5², 41.2.3³, 44.3⁴, 45.2⁵ “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13.7⁶, “Татварын ерөнхий” хуулийн 18.1.6⁷, “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 23.1⁸, Засгийн газрын 2013 оны 68 тогтоол⁹, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаал¹⁰, Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох” журмын 7¹¹ зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон хандив тусламжаар бэлтгэсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулснаас зарим хөрөнгө устаж үгүй болсон, ашиглалтын шаардлага хангахгүй байдалтай байна.

1.3.1 Тайланд онд төсвийн хөрөнгөөр болон төсөл хөтөлбөр, хандив тусламжаар 144836.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна. Мөн хяналт шалгалтын байгууллагуудаас өгсөн шийдвэрийн дагуу байгууллагын аж ахуйн материалын данс бүртгэлд тусгагдсан 205628.3 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэжээ.

1.3.2 Аудитын явцад төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөнд түүвэрчилсэн тооллого явуулахад алдаа зөрчил илрээгүй. Ерөнхий боловсролын сургуулийн өмч хамгаалах болон тооллогын комисс ашиглах боломжгүй актлах хөрөнгүүдийн талаарх судалгааг боловсруулж холбогдох газруудад нь хүргүүлэх шаардлагатай байна. Мөн байгууллагын өмч хамгаалах болон тооллогын комисс байгууллагын дотооддоо актлах боломжтой хөрөнгийн тооцоо судалгааг гаргаж захиралын шийдвэрээр данс бүртгэлээс хасах нь зүйтэй байна.

1.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 30.0 сая төгрөгийн гэрэлтүүлэг, “Андын илч” ХХК-ын хандив тусламжаар олгогдсон 60 ширхэг гэрэлтүүлэг болон ковш тракторыг тухайн үеийн сум, орон нутгийн удирлагууд данс бүртгэлд авах шийдвэр гаргаагүйгээс бүртгэл тайланд тусгаагүй байна.

¹ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсөв захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ

² Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

³ Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁴ Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно.

⁵ Төсвийн захирагчийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэнд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ

⁶ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁷ Бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх

⁸ Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна

⁹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ

¹⁰ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам

¹¹ Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй.

1.3.4 ОНХС-ийн хөрөнгөөр болон хандив тусламжаар хийгдсэн 90 гэрэлтүүлэгийг тус суманд “Шинэ сум” төсөл хэрэгжсэнтэй холбоотойгоор шугам сүлжээ, замын ажил хийгдэх явцад гүйцэтгэгч “Монгол дайван” ХХК сум орон нутгийн удирдлагатай зөвшилцөлгүйгээр буулгажээ. Уг гэрэлтүүлэгийг ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэн өгөөгүй, хариуцах эзэнгүй орхигдуулсан нь хөрөнгө устаж үгүй болоход хүргэсэн байна. Иймд “Монгол дайван” ХХК-г шүүхийн байгууллагад шилжүүлж гарсан хохирлыг төлүүлэх шаардлагатай байна.

1.3.5 Сумын хэмжээнд өмч хамгаалах комисс байгуулагдсан эсэх нь тодорхой бус байгаа бөгөөд тус комиссыг байгуулж нийтийн эзэмшлийн гудамж талбай, зам, цэцэрлэгт хүрээлэн болон бусад хөрөнгийн ашиглалт хамгаалалт, түүнд тавих хяналтыг эрчимжүүлэх журам боловсруулж ажиллах нь зүйтэй юм.

Дэд зорилт-2 : Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчдын үр дүнгийн гэрээний биелэлт

2

БҮЛЭГ 2

Сумын хэмжээнд баримтлах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулаагүйгээс зорилго, зорилтгүй ажилласан, үр дүнгийн гэрээг үнэлж дүгнээгүй, төрийн албаны стандарт алдагдсан байна.

Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн биелэлт 87.1%-тай гарчээ.

2.1.1 Сумын Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн дундаж биелэлтийг сумын ХШҮ-ний ажлын нэгжээс 87.1 хувьтай дүгнэсэн байна. Төсөв хөрөнгө шаардсан хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд хэрэгжээгүй нь биелэлт буурахад нөлөөлжээ. Жнь: Хилийн торыг сэргээн засварлах, 650 хүүхдийн сургуулийн байр, дотуур байр, биеийн тамир спортын төв, хүнсний бөөний худалдааны төв, мал нядалгааны цэг, Баруун-Урт - Бичигт чиглэлийн хатуу хучилттай зам, сумын төвд 150 хүүхдийн цэцэрлэг, бичигт боомтод 100 хүүхдийн цэцэрлэг барьж байгуулах ажлууд төсөв хөрөнгө батлагдаагүйгээс хийгдээгүй байна.

2.1.2 Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт 2017 оны хагас жилд хэрэгжүүлсэн байх арга хэмжээний биелэлтийг тооцож үзэхэд 19 хувийн хэрэгжилттэй байна. Тухайлбал, уул уурхайн компаниудтай ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан, ЭМТ болон сумын Онцгой байдлын гал унтраах аврах 47-р ангийг автомашины парк шинэчлэлт хийсэн, сумын төвд хатуу хучилттай 1 км зам тавигдсан зэрэг арга хэмжээнүүд бүрэн хэрэгжүүлжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, мал хамгаалах сангаас 20.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

2.2.1 Мал хамгаалах сан: Тайлант онд 56643.1 мянган төгрөгийн орлого төвлөрч 46404.0 мянган төгрөгийн зардал гарч 10239.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангийн ажил гүйлгээг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад сангийн

хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Малчдын чуулга уулзалт зохион байгуулахад 3320.0 мянга, үлийн цагаан оготно устгах зардалд 3345.6 мянга, “Гурван түмэн адуу”-ны баяр наадам зохион байгуулахад 13753.3 мянга төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 2011 оны 374¹² тоот журмыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ. Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хадлан тэжээл бэлтгэсний төлбөр 5751.0 мянган төгрөгийг мал хамгаалах санд төвлөрүүлж зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага хүргүүлээ.

2.2.2 Сум хөгжүүлэх сан: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, түүний эргэц хангалтгүй хэрэгжиж байна. Одоогоор 6 иргэний 60054.5 мянган төгрөгийн зээл төлөгдөөгүй хугацаа дуусч шүүхийн байгууллагад шилжүүлсэн, 10 иргэний 55454.6 мянган төгрөгийн зээл хуваарийн дагуу төлөгдөөгүй байна. Сум хөгжүүлэх сангаас олгож буй зээлийг ЗД-ын мөрийн хөтөлбөртэй уялдуулах, ЖДҮ-ийг дэмжсэн байх нөхцлийг хангах, хэрэгжих боломжтой төсөл арга хэмжээнд олгох, зээл авсан иргэн, хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох зэрэг шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож өгөөгүй байна. Эдгээр ажлын уялдаа холбоог хангаагүй, шаардлага хангасан төсөл арга хэмжээнд олгох байр сууриа өөрчилдөг, зохион байгуулалтын дутагдалтай үйл ажиллагаанаас болж зээл төлөгдөхгүй байна.

ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн 2016 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

2.3.1 Сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд 2016 онд үр дүнгийн гэрээг байгуулсан байна. Гэвч үр дүнгийн гэрээнд 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, зорилго, зорилтын хүрээнд хийх ажлыг оновчтой төлөвлөөгүй, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолттой уялдуулаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд гаргажээ.

2.3.2 Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу сумын ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээг дүгнээгүй, хяналт шинжилгээ хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 40.3¹³, үр дүнгийн гэрээний 4.2¹⁴ дахь заалтуудыг тус тус зөрчжээ.

2.3.3 Сумын Засаг дарга, ЗДТГ-ын даргатай 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулаагүй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй байна. Хэдийгээр ЗДТГ-ын дарга үр дүнгийн гэрээгээ байгуулаагүй боловч мэргэжилтнүүдтэйгээ үр дүнгийн гэрээ байгуулсан байна. Энэ нь нэг талаас ЗДТГ-ын дарга дээд шатны төсөв захирагчтайгаа үр дүнгийн гэрээгээ байгуулаагүй байхад мэргэжилтнүүдтэйгээ үр дүнгийн гэрээ байгуулсан нь хууль зөрчиж байгаа бөгөөд нөгөө талаас сумын Засаг дарга ямар үндэслэлээр ЗДТГ-ын даргатай үр дүнгийн гэрээ байгуулахаас татгалзсан зэрэг нь тодорхойгүй байдалд хүргэж байна. Эдгээр удирдах албан тушаалтнуудын ёс суртахууны зөрчил, хууль хэрэгжүүлэхгүй байгаа үйлдэлээс болж төрийн жинхэнэ албан хаагчдад хохиролтой байх нөхцөл байдал үүсчээ.

2.3.4 Удирдлагын үл ойлголцолоос ард иргэдэд очих төрийн үйлчилгээ удааширах, бодлого алдагдах, мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүйгээс ажил

¹² Мал хамгаалах сангийн тухай

¹³ Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

¹⁴ Төрийн жинхэнэ албан хаагч гэрээний биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор багтаан тайлагнаж, менежер 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэнэ.

цалгардах, ажилдаа хариуцлагагүй хандах, үр дүнгийн гэрээний биелэлтийг ажлын тайлан, холбогдох стандартын дагуу тайлагнаагүй зэрэг үйл ажиллагааны доголдол гарч байна.

Сумын Эрүүл мэндийн төв тодорхой зорилго, зорилт дэвшүүлээгүй, стратеги төлөвлөгөөгүй ажиллаж байна.

2.4.1 Эрдэнэцагаан сумын төсөвт байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт дэвшүүлсэн зорилго, зорилтыг үр дүнгийн гэрээний биелэлт, ажлын төлөвлөгөө, тайлан болон бусад холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

2.4.2 ИТХ: 2016 онд сумын ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн бүртгэл хангалтгүй, зарим тогтоол шийдвэрүүд архивт байхгүй, тогтоолын дугаар давхцсан зэрэг зөрчил дутагдал илэрлээ. Мөн ИТХ-аас тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, юу хийж ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь тодорхойгүй байсаар тухайн оныг үджээ. Сумын ИТХ нь хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой эрх, үүргүүдийг хэрэгжүүлэх ёстой байтал ямар ажил төлөвлөсөн, ирээдүйг яаж харж байгаа нь тодорхойгүйгээр урсгалаараа явж байна гэдэг зохисгүй. Иймд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих, төсөв хөрөнгийг үр ашигтай батлах, үндсэн чиглэлийн биелэлтэд онцгойлон ач холбогдол өгөх, сум орон нутгийн хөгжлийг түүчээлэгч байх зэрэг нутгийн өөрөө удирдах ёсны манлайлалыг үзүүлэх нь зүйтэй юм.

2.4.3 Бүрэн дүнд сургууль: 2016-2017 оны хичээлийн жилд “Сургуулийнхаа ахиц, амжилт, хөгжлийн төлөө “БИ ЧАДНА” гэсэн эрмэлзлэлийг тээж сурагч нь сургуулиа, сургууль нь сурагчаа дээдэлсэн хамт олон болох” зорилт дэвшүүлэн ажилласан байна. Зорилго зорилтоо биелүүлэх чиглэлээр сургалтын менежер болон багш ажилчид ажлын төлөвлөгөө гарган ажилласан. Дээрх зорилтыг дэвшүүлж, аймгийн ЗД-ын мөрийн хөтөлбөртэй уялдуулснаар “Математик” дэд хөтөлбөрийн хүрээнд сурагчдын сурлагын ахиц өмнөх онуудаас 5.8-6.5%-аар өссөн байна. Мөн ЯХИС-ийн хөтөлбөр, сургалтын цөм хөтөлбөрт хамрагдснаар сурагчдын сурлагын ахиц, уралдаан тэмцээнд хамрагдах хүрээ нэмэгдсэн байна. Сургалтын менежерүүд сургалтын чанар, амжилтын талаар анги, хичээл нэг бүрээр судалгааг өмнөх онуудтай харьцуулан гаргаж байгаа боловч сургалтын чанар амжилтыг бусад сум, аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийх, цаашид сурлагын чанар, амжилтыг ахиулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж ажиллах нь зүйтэй. Нийгмийн ажилтан сургуулийн сурагчдын судалгааг гаргаж гэмт хэрэг болон хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй сурагчдыг хамгаалах зорилгоор сумын цагдаагийн тасагтай хамтран ажиллаж гэрээ байгуулсан, хүчирхийлэлээс хамгаалах дуудлага хүлээн авах утас ажилуулснаар хүчирхийлэл болон гэмт хэрэгт өртөх хүүхдийн тоо өмнөх оноос буурсан байна. Мөн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх тусгай уриалга гаргаж хүүхэд бүрийн чадварыг оношлон авьяас чадварыг нээн ажилласанаар сурлага, урлаг, спортын төрөлд амжилт гаргажээ.

2.4.4 Хүүхдийн I цэцэрлэг: 2016-2017 оны хичээлийн жилд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д тулгуурлан 8 дэд зорилт дэвшүүлэн ажилласан. Сургалтын үйл ажиллагааг сайжруулах, сургалтын чанар, амжилтыг дээшлүүлэх зорилгоор багш, ажилчдад хувийн хэрэг хөтөлж, гаргасан алдаа дутагдлыг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллажээ. Мөн эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа гаргуулж үр дүнг тооцжээ. БСУГ-аас гаргасан хяналт үнэлгээ шинжилгээний үзүүлэлтээр тус цэцэрлэг сумдын цэцэрлэгүүдээс 2016 онд 10 дугаар байранд орсон үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх онуудаас 1-2 байр ахисан хэдий ч тийм сайн үзүүлэлт биш гэдгийг авч үзэх ёстой.

Сургалтын чанар амжилтыг ахиулах зорилгоор тодорхой ажлууд зохион байгуулж байгаа боловч судалгаагаар гарсан үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээг зөв төлөвлөх, хэрэгжилтэд байгууллагын хяналт шинжилгээг түлхүү авч хэрэгжүүлэх шаардлагатай.

2.4.5 Хүүхдийн II цэцэрлэг: 2016 – 2017 онд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Үүнд:

- ✓ СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэн туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх
- ✓ Сайн хичээл үйл ажиллагааны дэг соёлыг анги бүрт төлөвшүүлэх
- ✓ Баялаг бүтээгчдийг дэмжих жил болгосонтой уялдуулан орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжсэн бодлого баримтлана
- ✓ Гаднах тоглоомын талбайг тохижуулж сургалтанд ашиглана.

Хөтөлбөрийн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулсан нь дэвшүүлсэн зорилготой уялдсан үр дүнтэй ажил болжээ. Дотоод хяналт шалгалтын нэгж баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, ажил сайжруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж, тайлагнасан. Гэвч хяналтын мөрөөр ажил сайжруулах үүрэг даалгаврын хэрэгжилтийг дүгнээгүй нь үр дүнг тооцож ажиллах тал дээр хангалтгүй ажилласныг харуулж байна. БСУГ-аас сумдын цэцэрлэгүүдийг 2016 үйл ажиллагаагаар байр эзлүүлэхэд 12-р байранд орж өмнөх оноос 2 байраар ахисан байна.

2.4.6 Эрүүл мэндийн төв: Тайлант онд ямар зорилго зорилт дэвшүүлсэн нь тодорхойгүй байна. Аудитад үр дүнгийн гэрээ, үр дүнгийн гэрээний биелэлт хамрагдаагүй. НЭМ, эмнэлэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулсан боловч үр дүнг тооцоогүй байна. Статистикч эмч А.Түвшинжаргал нь шаардсан бичиг баримтыг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй тул түүнд хариуцлага тооцуулах саналыг байгууллагын даргад хүргүүлээд байна. Статистик мэдээнээс харахад эмнэлэгийн үйл ажиллагааг дүгнэхэд голлох үзүүлэлт болох хүүхдийн эндэгдэл өмнөх оноос өссөн байна. Цаашид эмнэлэгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ажлын хэсэг байгуулж хяналт шалгалтыг тогтмол хийх шаардлагатай байна.

2.4.7 Соёлын төв: 2016 онд зорилго, зорилт дэвшүүлж ажиллаагүй байна. Төсвийн шууд захирагч үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээг ёс төдий боловсруулжээ. БСУГ-аас Соёлын төвийн 2016 оны үйл ажиллагааг 66.8 хувиар үнэлсэн нь сумдын үнэлгээний дундажтай харьцуулахад 5.1-ээр бага байна. Мөн үйл ажиллагаагаар нь сумдын Соёлын төвүүдийг байр эзлүүлэхэд 8-р байранд оржээ. Ажилтнуудын хувийн хэргийг хөтлөлтийг хянахад зарим баримт бичгийн бүрдэл дутуу, мэдээллийг шинэчлээгүй нь ТАЗ-ийн 2004 оны 18-р тогтоолоор баталсан журмын 2¹⁵-р зүйлийг зөрчсөн байна.

2.4.8 ЗДТГ: 2016 онд “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх” эрхэм зорилгыг дэвшүүлж, сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт, хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг тооцсон боловч сумын ИТХ-д тайлангаа тавьж, хэлэлцүүлээгүй байна. Зорилгоо хангахын тулд зорилтуудыг дэвшүүлж, хүрэх үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр гаргаж, улирал, хагас, бүтэн жилээр биелэлтийг тооцож ажиллах шаардлагатай байна. 2017 онд МЭҮТ, Санхүү албанд тус тус 1 мэргэжилтний орон тоо дутуу ажиллаж байгаа бөгөөд сул ажлын

¹⁵ Төрийн албан хаагчийн хувийн хэрэг

байрыг нийтэд ил тод зарлаж, мэдээлээгүй нь Төрийн албаны тухай хуулийн 17.5¹⁶ дахь заалтыг зөрчжээ. Сумын ЗДТГ албан хэрэг хөтлөлтийн “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”, “Хадгаламжийн нэгжийн бүртгэл”-ийг холбогдох заавар, журмын дагуу хөтлөөгүй. Энэ нь нэг талаас байгууллагын ББНШК томилж ажиллуулаагүй, баримт бичгийн хөтлөлтөд тавих хяналт хангалтгүй, нөгөө талаас архив, албан хэрэг хөтлөлтийг мэргэжлийн бус хүн хариуцаж байгаатай холбоотой. Мөн ажилтнуудын хувийн хэргийн хөтлөлтийг ТАЗ-ийн 2004 оны 18-р тогтоолоор батлагдсан журмын дагуу хөтлөж, баяжуулалтыг тухай бүрт нь хийж хэвшүүлээгүй байна.

3

Дэд зорилт-3: Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт, түүнд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй эсэх

БҮЛЭГЗ

Гүйцэтгэх засаглалаас гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг бодитой үнэлдэггүй, төрийн албан хаагчид ажилдаа ёс зүйгүй хандаж, ажлын чиг үүрэг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Сумын Засаг даргын захирамжийн биелэлтийг тооцоогүй, үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.1.1 Сумын Засаг дарга 2016 онд аж ахуй нэгж байгууллага, орон нутгийн өмчийн улсын тооллого явуулах, статистик мэдээ тайлангийн график гаргах, холбогдох аян, өдөрлөг зохион байгуулах, мал сүргийн тарилга, шинжилгээ, угаалганд хамруулах болон цаг үеийн асуудалтай холбоотой 18 захирамж гаргаж, түүний хэрэгжилтийг зохион байгуулжээ.

3.1.2 Сумын ХШҮ-ний ажлын нэгжээс Засаг даргын захирамжийн биелэлтийн дундажыг 94.8 хувьтай үнэлсэн нь бодитой бус, үнэн зөв үнэлээгүй байна. Тухайлбал: “Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу “Алтан овоон”-ы энгэрт 1000 ширхэг, айл өрх, албан байгууллагуудын гадна 230 ширхэг нийт 1230 суулгац модыг арчилах үйл ажиллагаа хангалтгүй, ургалтын байдалд хяналт тавьж ажиллаагүй байна. Мөн “Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөө гарган сум, баг, байгууллагуудад сургалт, мэдээлэл хийсэн боловч угийн бичиг хөтлөсөн өрхийн тоо зорилтот түвшинд хүрээгүй байна. Мөн мал сүргийг угаалга, тарилга, шинжилгээнд хамруулахдаа хэдэн мал хамруулахаас хэдийг хамруулсан талаарх гүйцэтгэлийн хувийг гаргаагүй. Тухайн онд тус сумын малын зүй бус хорогдол өмнөх оноос 3.7 дахин өссөн байхад өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах захирамжийн биелэлтийг 100 хувь гэж дүгнэсэн нь үнэлгээг буруу тогтоодог дутагдлууд оршиж байгааг харуулж байна.

3.1.3 Захирамжийн биелэлтийг тооцохдоо зарим тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, хүрэх түвшинг тооцож, судалгаа шинжилгээ хийх, хэрэгжилтийн явцыг шалгаж, холбогдох заавар, зөвлөмж, арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

¹⁶ Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3.1.4 ИТХ-аас гаргасан тогтоол аудитад бүрэн хамрагдаагүй бөгөөд зарим тогтоол архивт хадгалагдаагүй, зарим тогтоол, шийдвэрийн дугаар давхцах зэрэг зөрчлүүд илэрсэн. Энэ нь өмнөх онуудад ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар тогтвор суурьшилтай ажиллаагүй, ажил хүлээлцэхдээ бичиг баримтыг протокол үйлдэж хүлээлцээгүй зэрэг шалтгаанаас баримт бичиг архивт хадгалагдаагүй байна.

Аудитын явцад өмнөх аудитуудаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангууллаа

3.2.1 Өмнөх онуудад хийгдсэн СТА-аар өгөгдсөн ЭМТөвийн 1.0 сая төгрөгийн акт, ОНХС-ийн 5.0 сая төгрөг, УТХО-ын аудитаар өгсөн 6.9 сая төгрөгийн албан шаардлага хугацаандаа хэрэгжээгүй байна. Аудитын явцад ОНХС-ийн зарцуулалт, УТХО-ын аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг хариуцсан албан тушаалтнаар гаргууллаа.

Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын 30%-ийг мэргэжилтнүүдийн ажлын цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбоотой өргөдөл гомдол эзэлж байна.

3.3.1 Тайлант онд ЗДТГ-т 179 санал хүсэлт, өргөдөл гомдол ирсний 147 буюу 82.1 хувь нь өргөдөл, гомдол байна. Үүнийг агуулгаар нь авч үзвэл: /Хүснэгт №.../

№	Өргөдөл, гомдлын агуулга	Тоо	Эзлэх хувь
1	Ажил хүссэн	15	10
2	Тусламж хүссэн	17	11
3	Газрын асуудлаар	7	5
4	ЭМТ-ийн тусламж, үйлчилгээтэй холбоотой	20	14
5	Өвс хадлантай холбоотой	20	14
6	Хог, усны асуудал	16	11
7	Сумын төвийн шинэчлэл төсөлтэй холбоотой	7	5
8	Мэргэжилтнүүдийн ажлын цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбоотой	45	30

3.3.2 Нийт өргөдөл гомдлын ихэнх хувийг төрийн албан хаагчдын ажил үүрэг, цаг ашиглалттай холбоотой ирүүлсэн нь төрийн албан хаагчдын ёс зүй, удирдлагын хяналт, шинжилгээ хангалтгүй байгаагийн илрэл юм.

3.3.3 Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүртгэн, сумын Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээ, хуулиар хүлээсэн чиг үүрэгт нь хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь мэдэгдэл өгч ажилласан ба өргөдөл, гомдлын барагдуулалтыг 85 хувьтай гэж тайлагнажээ.

3.3.4 Иргэдээс ирсэн нийт өргөдөл гомдлын 45 буюу 30%-ийг албан хаагчдын цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбоотой гаргасан байна. Аудитын явцад төсөвт байгууллагуудын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт явуулахад хангалтгүй үр дүн гарч байгаа нь мэргэжилтнүүдийн цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж ажиллаагүй байна.

3.3.5 Мөн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 14%-ийг эзэлж байгаа боловч өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.3.6 Дээрх байдлаас дүгнэж үзэхэд иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг нэр төрлөөр нь ангилж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж санал хүсэлт, алдаа дутагдалыг арилгах талаар тодорхой ажил зохион байгуулагдаагүй байна.

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлжээ

3.4.1 Сумын төсөвт байгууллагуудын даргын шийдвэрээр дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулсан байна. Тухайлбал: Сургууль, цэцэрлэгүүд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг гаргаж ил тодын самбарт байршуулсан хяналт шалгалтын хуваарийн дагуу хийж гарсан алдаа зөрчлийг арилгуулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, тээврийн хөлснөөс ХХОАТ-ыг төвлөрүүлээгүй, төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаагүй боловсруулсантай холбоотойгоор орлого 38.6 сая төгрөгөөр тасарчээ.

Сумын хэмжээнд баримтлах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулаагүйгээс зорилго, зорилтгүй ажилласан, үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнээгүй, төрийн албаны стандарт алдагдсан байна.

Гүйцэтгэх засаглалаас гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг бодитой үнэлдэггүй, төрийн албан хаагчид ажилдаа ёс зүйгүй хандаж, ажлын чиг үүрэг хангалтгүй хэрэгжүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

- Сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудаас авах хог хаягдлын үнэ тарифийг баталж, мөрдүүлэх
- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах хүсэлтийг аймгийн ТАСЗ-д хүргүүлж, шалгалтанд тэнцсэн хүнийг уг орон тоонд ажиллуулах
- Тайлант онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго зорилтыг дэвшүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

Засаг даргад:

- Төсөвт байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийг сайжруулж, хяналт тавьж ажиллах

- Хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ тухайн зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, дүн шинжилгээ, судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгаж байх
- ЗДТГ-ын даргатай цаг хугацаанд нь үр дүнгийн гэрээг байгуулж, гэрээний биелэлтэнд хяналт тавьж, иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж ажиллах
- Шүүхийн шийдвэрээр цалингийн сангаас олгосон нөхөн олговрыг хууль тогтоомжид заасны дагуу буруу шийдвэр гаргасан холбогдох байгууллага, албан тушаалтанаар төлүүлж, төсвийг хохиролгүй болгож байх /Төрийн албан хаагчийг үндэслэлгүй халсан тохиолдолд/
- “Шинэ сум” төслийг хэрэгжүүлэгч “Монгол дайван” ХХК-аас хөрөнгийг нөхөн төлүүлэх, сумын “Өмч хамгаалах комисс” байгуулж, комиссын ажиллах журмыг баталж, мөрдүүлэх

ЗДТГ-г:

- Төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр холбогдох журмын дагуу дүгнэж байх
- Баримт бичиг нягтлан шалгах комиссыг томилж, үйл ажиллагаа явуулах журмыг батлах
- Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах хүсэлтийг аймгийн ТАСЗ-д хүргүүлж, шалгалтанд тэнцсэн хүнийг уг орон тоонд ажиллуулах
- Албан хаагчдийн ажлын цаг ашиглалт, ажил үүрэгтэй холбогдуулан гарсан алдаа дутагдлыг арилгах, гаргасан алдаа дутагдалд тохирох сахилгын шийтгэл оногдуулж байх

Эрүүл мэндийн төвд:

- Тайлант онд байгууллагын зорилго зорилтыг тодорхойлж, ажлын төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тооцож ажиллах
- Төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй сургалт сурталчилгааны үр дүнг тооцож, тайлан мэдээг цаг тухай бүр гаргах

Соёлын төвд

- Үйл ажиллагааны орлогыг хүлээн авах бүрт анхан шатны баримтыг хөтөлж Сангийн сайдын 276 тушаалаар батлагдсан журмын дагуу харилцах дансанд төвлөрүүлж байх
- Худалдан авсан бараа материалыг тухай бүр бүртгэж тайлагнаж байх

Төсөвт байгууллагуудад

- Хөрөнгө захиран зарцуулах, албан тушаалтан, томилох, чөлөөлөх болон бусад тогтоол, захирамж тушаал шийдвэрийг төлөвлөхдөө, тушаалын үндэслэлийг

СБА-2017/05-ГА


Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн

шийдвэрийн заалт бүрээр үнэн зөв тодорхойлж, эрх зүйн актыг боловсруулж байх

- Статистик мэдээ, тайлан, судалгаанд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллах

Санхүү төрийн сангийн алба, татварын байцаагчид

- Татварын орлогыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, орлого бүрдүүлэх талаар төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах



ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОРС.АРИУНБАЯР
Ө.ЗОЛЗАЯА

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.НАРАНТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ДАВАА

18

